

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/185/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Нурлан  
Утас: 88403281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын гол асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Төлбөрийн акт .....	15
5.2 Албан шаардлага .....	16
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

МОНГОЛ АЛТАЙН ХАДНЫ ЗУРГИЙН  
ЦОГЦОЛБОРЫН ХАМГААЛАЛТЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГА Б.ӨМИРБЕК  
ТАНАА

2023.02.03 № 18

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг иж бүрэн толилуулж, тодруулсан байна.

#### Аудитын гол асуудал

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар алдаа, зерчил илрээгүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Монгол алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд толилуулж, тодруулаагүй асуудал гараагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>15081700.00</u></b>	<b><u>20021400.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	15081700.00	20021400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	15081700.00	20021400.00
35420	Аж ахуйн материал	0.00	408100.00
35470	Бусад хангамжийн материал	15081700.00	19613300.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7608061.98</u></b>	<b><u>10174410.42</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7608061.98	10174410.42
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	6630562.01	9426910.49
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3600700.00	7587600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-360231.69	-1637355.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2858451.50	3268451.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-166742.80	-490170.97
39217	Ном	698385.00	698385.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	977499.97	747499.93
39301	Програм хангамж	1150000.00	1150000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-172500.03	-402500.07
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>22689761.98</u></b>	<b><u>30195810.42</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>22689761.98</u></b>	<b><u>30195810.42</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	22689761.98	30195810.42
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	22689761.98	30195810.42
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	22689761.98
51220	Тайлант үеийн үр дүн	22689761.98	7506048.44
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>22689761.98</u></b>	<b><u>30195810.42</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>201730536.50</u></b>	<b><u>201295300.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>4962236.50</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4962236.50	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4962236.50	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4962236.50	0.00

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>196768300.00</b>	<b>201295300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	194510700.00	196295300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	194510700.00	196295300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2257600.00	5000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2257600.00	5000000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>179040774.52</b>	<b>193789251.56</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>179040774.52</b>	<b>193789251.56</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	133049463.62	173004743.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	85582858.10	116579454.70
210101	Үндсэн цалин	72562026.00	90757750.70
210102	Нэмэгдэл	8507662.10	16834793.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4513170.00	4993800.00
210104	Урамшуулал	0.00	3993111.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11064841.00	14834937.09
210201	Тэтгэврийн даатгал	7641526.24	10096158.39
210202	Тэтгэмжийн даатгал	855829.19	1186794.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	684661.81	949435.66
210204	Ажилгүйдлийн даатгал	171165.38	237358.59
210205	Эрүүл мэндийн даатгал	1711658.38	2365189.99
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	3513500.00	4800000.00
210304	Байрны түрээс	3513500.00	4800000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1804070.00	1342600.00
210401	Бичиг хэрэг	282200.00	97500.00
210402	Тээвэр, шатахуун	957470.00	737400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	282200.00	225500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282200.00	282200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2257600.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2257600.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	28127120.00	33617200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27877120.00	33338400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250000.00	278800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	699474.52	1830551.56
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	699474.52	1830551.56
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	45991310.90	20784508.21
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	45991310.90	20784508.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45991310.90	20784508.21
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>22689761.98</u></b>	<b><u>7506048.44</u></b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	0.00	0.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>22689761.98</u></b>	<b><u>7506048.44</u></b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>196768300.00</u></b>	<b><u>201295300.00</u></b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>196768300.00</b>	<b>201295300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	194510700.00	196295300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	194510700.00	196295300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2257600.00	5000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2257600.00	5000000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>193423000.00</u></b>	<b><u>196898400.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>193423000.00</b>	<b>196898400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>147431689.10</b>	<b>176113891.79</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	85582858.10	116579453.45
210101	Үндсэн цалин	72562026.00	90757750.70
210102	Нэмэгдэл	8507662.10	16834793.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4513170.00	4993798.35
210104	Урамшуулал	0.00	3993111.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11064841.00	14834938.34
210201	Тэтгэврийн даатгал	7641526.24	10096159.64
210202	Тэтгэмжийн даатгал	855829.19	1186794.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	684661.81	949435.66
210204	Ажилгүйдлийн даатгал	171165.38	237358.59
210205	Эрүүл мэндийн даатгал	1711658.38	2365189.99
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	3513500.00	4800000.00
210304	Байрны түрээс	3513500.00	4800000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1804070.00	1342600.00
210401	Бичиг хэрэг	282200.00	97500.00
210402	Тээвэр, шатахуун	957470.00	737400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	282200.00	225500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282200.00	282200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2257600.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2257600.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	270100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	270100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	43208820.00	38286800.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42877120.00	38008000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	331700.00	278800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45991310.90</b>	<b>20784508.21</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	45991310.90	20784508.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45991310.90	20784508.21
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>3345300.00</u></b>	<b><u>4396900.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3345300.00</b>	<b>4396900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3345300.00</b>	<b>4396900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	3345300.00	4396900.00
222001	Тоног төхөөрөмж	3345300.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		4396900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-3345300.00</u></b>	<b><u>-4396900.00</u></b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр
			Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	22,689,761.98	22,689,761.98
C08	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>22,689,761.98</b>	22,689,761.98
D01	<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>22,689,761.98</b>	22,689,761.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>22,689,761.98</b>	22,689,761.98
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	7,506,048.44	7,506,048.44
D09	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>30,195,810.42</b>	30,195,810.42

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	196360700.00	175523791.79
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	196360700.00	175523791.79
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	196360700.00	175523791.79
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	134396100.00	116579453.45
210101	Үндсэн цалин	100249300.00	90757750.70
210102	Нэмэгдэл	25000000.00	16834793.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5000000.00	4993798.35
210104	Урамшуулал	4146800.00	3993111.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	16800700.00	14834938.34
210201	Тэтгэврийн даатгал	11424700.00	10096159.64
210202	Тэтгэмжийн даатгал	1344000.00	1186794.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	1075300.00	949435.66
210204	Ажилгүйдлийн даатгал	268800.00	237358.59
210205	Эрүүл мэндийн даатгал	2687900.00	2365189.99
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4800000.00	4800000.00
210304	Байрны түрээс	4800000.00	4800000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1343000.00	1342600.00
210401	Бичиг хэрэг	113500.00	97500.00
210402	Тээвэр, шатахуун	766800.00	737400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	225500.00	225500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	237200.00	282200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2420100.00	2420100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2420100.00	2420100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	36600800.00	35546700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35274600.00	35267900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	558000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	274000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	278800.00	278800.00
210807	Газрын төлбөр	215400.00	0.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	196295300.00	196295300.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	196295300.00	196295300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	196295300.00	196295300.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00

<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	12.00	11.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	6.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>12.0</b>	<b>11.0</b>
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4.00	4.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	7.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>4987000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>4987000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	4987000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	4987000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,987,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>13000.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	13,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	5000000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	5000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,000,000.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

##### **Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь Монгол Алтайн хадны зургийн цогцолборын эх төрх, бүрэн бүтэн байдлыг хамгаалах сурталчлах, хөгжүүлэх чиг үүрэгтэй байгууллага.

Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь “Хамгаалалтын захиргааны газар нутаг дахь түүх, соёлын дурсгал, соёлын биет бус өвийн бүртгэл, судалгаа хийх, баримтжуулах мэдээллийн сан бүрдүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 27 арга хэмжээг дэвшүүлж ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь нь Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

## Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, батлуулж ашигладаг байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7.5 сая төгрөгөөр буюу 33.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	15,081.7	20,021.4	4,939.7
Үндсэн хөрөнгө	7,608.1	10,174.4	2,566.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>22,689.8</b>	<b>30,195.8</b>	<b>7,506.0</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	22,689.8	30,195.8	7,506.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>22,689.8</b>	<b>30,195.8</b>	<b>7,506.0</b>

Мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гараагүй бол бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын данс 4.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 2.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 4.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч үндсэн хөрөнгөд 1.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 7.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс зарлагын нийт 346.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 7.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 0.3 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 3.5 сая төгрөгөөр, Нормативт зардал 0.5 сая төгрөгөөр, томилолт, зочны зардал 1.7 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 95.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 51.5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,5 сая төгрөгөөр буюу нийт 156.4 сая төгрөгөөр буруулж, 196.3 сая төгрөгөөр баталсан байна. Нийт бууруулсан төсвийн төслийн 60.9 хувь буюу 95.4 сая төгрөг нь байгууллагад машин худалдан авахаар төлөвлөсөн төсөв байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 149.9 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 196.3 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 196.3 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 175.5 сая төгрөг буюу 89.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 20.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой. Жилийн эцэст улсын төсөвт 20.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	161,496.1	140,665,9	-20,830.2	87.1%
2	Түүх, соёлын дурсгалт зүйлсийг	34,864.6	34,857.9	-6.7	99.9%
	<b>Дүн</b>	<b>196,360.7</b>	<b>175,523.8</b>	<b>-20,836.6</b>	<b>89.4%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь 2022 онд 5.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч гүйцэтгэлээр 4.987 сая төгрөгийг зарцуулж 0.013 сая төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 179.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшил 17.8 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1.1 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн 19.8 сая төгрөгийн хэмнэлт нь байгууллага нь машингүй байсантай холбоотой жолоочийн орон тоонд хүн авч ажиллуулаагүй байгаатай холбоотой.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлыг 1.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 99.3% байна. Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 28.5 сая төгрөгийн 17 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлсэн байна.

Соёлын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2022 оны эхний 3 улиралд хяналт шалгалт хийгдэж дотоод аудитын дүнгээр шилэн дансны хууль, тогтоомжийн хэрэгжилт “хангалттай” гэж дүгнэсэн байна. Үүнд: 1-р улиралд 98.6 хувь, 2-р улиралд 98.6 хувь, 3-р улиралд 99.1 хувьтай гэж тус бүр үнэлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илэрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр хийсэн ба алдаа зөрчил илрээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, албан шаардлага өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Байхгүй

#### **5.1 Төлбөрийн акт**

Байхгүй.

